



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020. 03. 13.

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн эчнээ хурлын саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Э-транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Тусгаар тогтнолын ордны хойд талд City Tower зочид буудлын 25-р давхар дахь хурлын өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
 - b. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
 - c. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - e. ТУЗ-ийн 2020 оны цалин урамшууллын төсөв батлах
 - f. Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 19 дэх өдөр буюу 2020 оны 04 сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээллэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2019 оны 04 сарын 02-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын

жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2020 оны 04 сарын 29-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Э.Батболд, хурал зохион байгуулах комиссийн даргаар С.Ганбат, гишүүнээр Э.Ариунтуяа, тооллогын комиссын даргаар Э.Уянга, гишүүнээр Н.Өнөрбаян нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
11. ХЭХ хуралдуулах ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Э.БАТБОЛД/